

УЛААНБААТАР ХОТЫН РӨН-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД 2024.12.02-2024.12.31 ХҮРТЭЛ ХИЙСЭН СУУРИН ХЯНАЛТЫН МЭДЭЭ

Тайлангийн дугаар: Хяналт/2025/01

Хэвлэсэн огноо: 2025.01.07

1. Хэмжилтийн зорилго, хамрах хүрээ:

Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын FM радио нэвтрүүлэх станцад MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын шаардлагыг мөрдүүлэх зорилготой.

2. Хэмжилт хийсэн огноо, байршил, зураг:

№	Огноо	Хэмжилт хийсэн хаяг	Байршлын өргөрөг, уртраг
1	2024.12.02-2024.12.31	Улаанбаатар хотын СХД-ийн 34-р хороонд байрлах ХХЗХ-ны РДӨНХТ-ийн цамхагт байрших суурин хяналтын станц	/47°54'51.50"N 106°45'43.33"E/



Зураг 1. Хэмжилт хийсэн FMS-2020 суурин хяналтын станцын байршил

3. Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж:

FMS-2020 суурин хяналтын станц /RmcFX2dm02Mn/


4. Норматив бичиг баримт:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандарт

5. Хэмжилтэд оролцсон бүрэлдэхүүн:

Хэмжилт хийж гүйцэтгэсэн			
№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	М.Болдбат	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын ахлах инженер
2	Ж.Дөлгөөн	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын инженер
3	М.Чагнаадорж	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын инженер

6. Хэмжилт хийх үеийн зураг:



Зураг 2. Радио давтамжийн 88 МГц-108 МГц-ийн зурвасын хэмжилт

7. Хэмжилтийн дүн:

Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв нь радио давтамжийн суурин хяналтыг тогтмол хийдэг. Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 33 үйлчилгээ эрхлэгчийн нэвтрүүлэх станцууд хамрагдахаас 32 станцад 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 31-ний өдрүүдэд хяналт, шалгалт хийж ажиллаа. РӨН-ийн хэт богино долгионы 22800147 дугаарын тусгай зөвшөөрөлтэй Хэмнэлт долгион медиа групп ХХК-ийн 91.7 МГц-ийн FM радио станц нь үйл ажиллагаагаа түр хугацаанд зогсоосон байгаа бөгөөд энэ тухайгаа тус хороонд 2024 оны 10 дугаар сарын 16-ны 24/14

тоот албан бичгээр мэдэгдсэн тул энэ удаагийн хяналтад хамрагдаагүй болно.

Хяналтын үр дүнд РӨН-ийн хэт богино долгионы 22800060 дугаарын тусгай зөвшөөрөлтэй Дижитал радио ХХК-ийн 99.7 МГц-ийн FM радио станц нь MNS 4909:2000 стандартад заагдсан давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц-ээс хэтэрсэн нь тогтоогдсон тул тус хорооноос тухайн FM радио станцын үйлчилгээ эрхлэгчид дээрх стандартын шаардлагыг мөрдөж ажиллах тухай албан бичиг хүргүүлээ.

7.1 Үйл ажиллагаагаа түр зогсоосон:


№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Хэмнэлт долгион медиа групп ХХК	22800147	91.7

7.2 Стандартын шаардлагыг хангасан:


MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын 5-р зүйлд заасан давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц, нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт 2 кГц, хэрэглэх зурвасын өргөн 300 кГц-ээс хэтрэхгүй гэсэн шаардлагыг 31 FM радио станц хангаж үйл ажиллагаа явуулж байгаа нь хэмжилтээр тогтоогдсон. Үүнд:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Эм Жи Эл Радио ньус ХХК	22800192	88.3
2	СКОД ХХК	22800167	88.8
3	Сета тех ХХК	22800193	89.3
4	Эх болсон зургаан зүйл НҮТББ	22800186	89.7
5	Манай аялгуу эф эм ар ХХК	22800178	90.5
6	Монгол комикс ХХК	22800159	91.1
7	Смарт коммуникэйшн ХХК	22800158	92.1
8	Тэргүүн медиа ХХК	22800146	92.5
9	Шүхэр ТББ	22800117	95.1
10	Хүүхэд, ирээдүй, соёл, боловсрол сан ТББ	22800097	95.7
11	Авторадио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ	22800070	96.3
12	Эх элгэн нутаг ХХК	22800114	96.9
13	МБШТГ	22800071	97.5
14	Радиоком Монгол ХХК	22800028	98.1
15	Монголиан Мюзик Медиа ХХК	22800024	98.9
16	Нью медиа ХХК	22800026	99.3
17	РФ ХХК	22800005	100.1
18	НС холбоо ХХК	22800040	100.5
19	РТҮС УТҮГ	22800044	100.9

20	Агрегатор ХХК	22800022	101.7
21	Эм Эс Жи Эм Эл ХХК	22800175	102.1
22	Бадруун ХХК	22800006	102.5
23	РТҮС УТҮГ	22800044	103.1
24	Медиа холдинг ХХК	22800009	103.6
25	Ви Өү Эм ХХК	22800052	104.0
26	Салхи Энтертейнмент ХХК	22800057	104.5
27	Чугу ХХК	22800037	105.5
28	РТҮС УТҮГ	22800044	106.0
29	Стандарт Ви Оү Эй ХХК	22800001	106.6
30	И Зэт Эф Эм ХХК	22800038	107.0
31	Билэг санаа ХХК	22800018	107.5



Зураг 3. Зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлтын хэмжилтийн үр дүн




Зураг 4. Хэрэглэх зурвасын өргөний хэмжилтийн үр дүн

7.3 Стандартын шаардлагыг хангаагүй:


MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангаагүй буюу давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц-ээс хэтэрсэн хуулийн этгээдийн мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Дижитал радио ХХК	22800060	99.7



Зураг 5. Давтамжийн хазайлтын максимум утгын хэмжилтийн үр дүн

7.4 Ажиллаж буй дахин дамжуулах радио станцууд:



Зураг 6. Радио давтамжийн 76 МГц-86 МГц-ийн зурвасын хэмжилт

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт ажиллаж буй хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцуудын мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Чугу ХХК	22830003	76.9
2	Сета тех ХХК	22830002	77.3
3	Манай аялгуу эм эм ар ХХК	22830004	77.7
4	Эх элгэн нутаг ХХК	22830005	78.1
5	РФ ХХК	22830006	78.9
6	Билэг санаа ХХК	22830013	79.7
7	Бадруун ХХК	22830009	80.5
8	Эм Эс Жи Эм Эл ХХК	22830012	82.1
9	И Зэт Эф Эм ХХК	22830008	83.3
10	Дижитал радио ХХК	22830017	83.7
11	Радиоком Монгол ХХК	22830020	84.1
12	Салхи Энтертейнмент ХХК	22830015	84.5

8. Дүгнэлт:

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хэт богино долгионы FM радио нэвтрүүлэх станцуудын 97% нь MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын шаардлагыг ханган ажиллаж байна.

Дээрх стандартын шаардлагыг хангахгүй байгаа шалтгаан нь тухайн FM радио нэвтрүүлэх станцын нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдийн тохиргооноос хамаарч байна.

Иймд хэт богино долгионы FM радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид хүлээн авах талд хэмжигдэж буй радио долгионы параметруудыг стандарт хэмжээнд байлгах, сонсогчдод сонсогдож буй дууны сонсголын чанарыг сайжруулахын тулд нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдэд тухайлбал антен, нэвтрүүлэгч, чадлын өсгөгч, холболтын кабель (фидер кабель, аудио кабель)-д тогтмол техникийн хяналт, үзлэг, үйлчилгээ хийж байх, студийн дууны холигч пультны түвшинг тогтмол хянаж, стандарт хэмжээнд тохируулж байхыг зөвлөж байна.